

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д шаардлагатай
 шууд худалдан авалтын зар №36

Тендер шалгаруулалтын дугаар: ДААТҮТӨХК/20260601417
 Төсөвт өртөг: 19,800,000 төгрөг

2026.02.24

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	ХН	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Аюултай хог хаягдлын гэрээ байгуулж, устгуулах	багц	1	- Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах тусгай зөвшөөрөлтэй, тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй байх - Аюултай хог хаягдал тээвэрлэхэд стандартын шаардлага хангасан машин механизмтай байх - Тухайн машиныг жолоодох эрхийн үнэмлэхтэй байх

“АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГУУЛАХ”

АЖЛЫН ДААЛГАВАР

1	Захиалагч байгууллага	“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК
2	Захиалагч байгууллагын хаяг	Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар баг Өөрийн байр
3	Аюултай хог хаягдал устгуулах үндэслэл	Хог хаягдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.1.1 заалт, Засгийн газрын 116-р тогтоолыг хэрэгжүүлэх
4	Зорилго, хэрэгцээ шаардлага	“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааны явцад үүссэн аюултай хог хаягдлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, журамд нийцүүлэн аюулгүй, байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр цуглуулах, тээвэрлэх, устгуулах үйлчилгээг худалдан авахад оршино.
5	Гүйцэтгэх ажлын төрөл, тоо, хэмжээ	Төмөртэй уурхай, Төмөртолгой уурхай, Гангийн үйлдвэрт үйл ажиллагааны явцад үүссэн түр хадгалагдаж байгаа аюултай хог хаягдал. Үүнд:

		1. Шатах тослох материал шингээсэн арчдас материал 2. Машин механизмын тосны, түлшний шүүр, 3. Шатах тослох материалаар бохирдсон шланг, резинэн хоолой, эд анги. 4. Тос, тосолгооны материалд бохирдсон сав, баглаа боодол 5. Бусад Дээрх хог хаягдлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар устгуулах. • Аюултай хог хаягдал тээвэрлэгч нь тусгай тоноглогдсон, аюулгүй байдлыг бүрэн хангасан “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээ бүхий тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрлах Төмөртэй уурхай, Дархан-Уул аймгийн Хонгор суманд байрлах Төмөртолгой уурхай, Дархан-Уул аймгийн Дархан суманд байрлах Гангийн үйлдвэрээс тус бүр тээвэрлэлт хийнэ. • Захиалагч байгууллагаас гарч буй аюултай хог хаягдлын нэр төрөл, тоо хэмжээнээс хамааруулан нэгж, салбар бүр жилд 1-2 удаагийн тээвэрлэлт хийнэ. • Гүйцэтгэгч байгууллагад захиалга өгснөөс 7 хоногийн дотор тээвэрлэлтийг хийж гүйцэтгэнэ. • Тээвэрлэлт хийх үед 2 талаас хог хаягдлыг шилжүүлэн өгсөн тухай акт үйлдэж, дагалдах бичиг хөтлөн баталгаажуулалт хийнэ. • Ажлын явцад гарсан аливаа осол, зөрчил, байгаль орчинд учирсан хохирлыг гүйцэтгэгч бүрэн хариуцна. Захиалагч тал ажлын гүйцэтгэлд хяналт тавина. • Аюултай хог хаягдлыг устгах, тээвэрлэх зардлыг кг тутамд тооцож тээвэрлэлт бүрийн дараа ажлын тайлан, нэхэмжлэлийг үндэслэн төлбөрийг барагдуулна.
6	Байршил	Сэлэнгэ аймгийн Хүдэр сум, Дархан-Уул аймгийн Хонгор сум, Дархан-Уул аймгийн Дархан сум
7	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	• Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах тусгай зөвшөөрөлтэй, тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй байх • Аюултай хог хаягдал тээвэрлэхэд стандартын шаардлага хангасан машин механизмтай байх • Тухайн машиныг жолоодох эрхийн үнэмлэхтэй байх
8	Ажил гүйцэтгэх хугацаа	Дуудлага өгсөн өдрөөс хойш 7 хоногийн хугацаанд багтаан хог хаягдлын ачилт хийх бөгөөд жилийн турш хамтран ажиллана.
9	Ажлын гүйцэтгэлийг үнэлэх	Хог хаягдал ачуулсан акт, аюултай хог хаягдлын дагалдах бичиг, устгалын дараах тайлан зэргийг үндэслэн гэрээг дүгнэнэ. Үүнд: Аюултай хог хаягдал устгасан тухай акт, тайлан Тээвэрлэлтийн дагалдах бичиг баримт

Жич:

- Урьдчилгаа төлбөр олгохгүй
- Төлбөрийг бараа нийлүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.
- Үйл ажиллагааны чиглэл нь төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа /Гадаад худалдаа/ байх.

Бүрдүүлж ирүүлэх материал:

- Албан бичиг /Үнийн санал, нийлүүлэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/
- Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ, Татварын өргүй тухай тодорхойлолт
- Нийлүүлэх барааны үзүүлэлт, танилцуулга, бусад нотлох баримт
- Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл хаяг, утасны дугаар

**Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

**Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах мэйл хаяг:**

procurement2@dmp.mn

Утас/факс: 7509-0044